Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа

эсэхийг судалж үзэхэд Захирлын 2020 оны 05 дугаар сарын 28-ны А/54 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ батлуулан мөрдөн ажиллаж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтантай бөгөөд дотоод аудитын ажилтангүй, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,918,048.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 249,180.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40,872,423.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 408,724.2 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,569,581.1 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр тус тус нэмэгдэж, авлага, цэвэр хөрөнгийн өмчийн данс буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.9	9.0	2.1
Авлага	152,641.3	76,728.1	-75,913.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	3,504,814.4	3,539,742.7	34,928.3
Үндсэн хөрөнгө	59,005,704.1	56,477,105.8	-2,528,598.4
Нийт хөрөнгө	62,633,166.7	60,093,585.6	-2,569,581.1
Өр төлбөр	8,700.8	74,561.9	65,861.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	62,654,465.9	60,019,023.7	-2,635,442.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	63,633,166.8	60,093,585.6	-2,569,581.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9.0 мянган төгрөг болж 2.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,539,742.7 мянган төгрөг болж 34,928.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хандив тусламжаар авсан бараа материал өссөнтэй холбоотой байна.

Байгууллагаас авах авлагын өмнөх оны дансны үлдэгдэл урд онд 152,641.3 мянган төгрөг буурч 75,913.2 мянган төгрөг болсон байна. Байгууллагаас авах авлага 76,030.4 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 697.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 56,477,105.8 мянган төгрөг болж 2,528,598.3 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,058,182.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар 2,366,561.6 мянган төгрөг, хандиваар авсан хөрөнгө 128,204.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж нийт 3,552,948.6 мянган төгрөгийн орлого авсан байна.

Биет бус хөрөнгө 6,388,092.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант жилд тооцсон 16,302.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь 74,561.9 мянган төгрөг байгаагаас 58,819.2 мянган төгрөгийн өглөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байна. Энэ нь 2020 оны 12-р сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, тооцоо нийлсэн актаараа баталгаажиж байна.

Бусад 15,742.7 мянган төгрөгийн өр төлбөр нь бусад байгууллага болон ажиллагсадтай холбоотой өглөг байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,307,096,0 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өссөн 2,307,096,0 мянган төгрөгийн орлого нь улсын төсвийн санхүүжилтээс 1,077,001.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилтээс 901,521.8 мянган төгрөг, хандив тусламжийн орлого 612,515.8 мянган төгрөгөөр тус тус өссөн ба үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орсон орлого 110,374.2 мянган, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 137,453.8 мянган нэмэлт санхүүжилтээр УИХ-аас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон Олон Улсын байгууллагаас авах хөнгөлөлтэй зээлийн орлого 36,115.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зарлагын дүн өмнөх оноос 1,874,461.2 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1,917,010.0 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 243,946.9 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 122,819.1 мянган, норматив зардал 660,905.8 мянган, томилолтын зардал 31,757.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 30,584.1 мянган, урсгал шилжүүлэг 67,111.9 мянган төгрөгөөр тус тус өсөж, харин хангамж, бараа материалын зардал 379,565.4 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 323,821.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 496,227.2 мянган, хүү 60.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих 22,960,635.9 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн

санхүүжилтээр 11,262,484.7 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 795,158.7 мянган төгрөгийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 35,018,279.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 35,018,279.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг өөрчлөлт оруулалгүй баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2020 онд анх батлагдсан төсөвт 692,660.1 мянган төгрөгийн тодотгол хийгдэж, 35,710,939.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогын эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр нийт 35,072,163.5 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, зардлын гүйцэтгэл 98.2 хувьтай байна.

Төсвийн орлого бүрдүүлэлтэд:

1. Улсын төсвийн санхүүжилтээс 24,096,958.9 мянган төгрөг.
2. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 19,062 үйлчлүүлэгчийн 5,556,102.4 мянган төгрөг, амбулаторийн тусламж үйлчилгээнд 148,613 үйлчлүүлэгчийн 2,374,088.4 мянган төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн нь нийт эрүүл мэндийн даатгалын сангаас 10,468,303.8 мянган төгрөгийн санхүүжилтийн 75.7 хувийг эзэлж, үлдэх 24.3 хувийг оношилгоо, шинжилгээ, хорт хавдар, хими, өндөр өртөгт мэс заслын тусламж Үйлчилгээний санхүүжилт эзэлж байна.
3. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 506,893.9 мянган төгрөг

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 638,775.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар хэмнэгдсэн нь нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 457,184.4 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14,514.1 мянган, хангамж, бараа материалын зардал 2,239.6 мянган, нормативт зардал 123,290.2 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 286.6 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 597.7 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 25,283.5 мянган, урсгал шилжүүлэг 14,179.8 мянган, томилолтын зардал 1200.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн 21,269.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 622,543.4 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 132,436.8 мянган төгрөгийн нийт 754,980.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 52,223.2 мянган, хангамж, бараа материалын зардалд 141,117.1 мянган, норматив зардалд 15,600.0 мянган, эд хогшил, урсгал засварын зардалд 25,249.4 мянган, томилолтын зардалд 78,503.6 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 44,191.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 394,480.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 69,542.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих шилэн дансны хуулийн дагуу байршуулах 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 158 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл (Дараа жилийн төсвийн төсөл, Худалдан авах ажиллагааны тайлан, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл)-ийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт,

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 246.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд 3 албан шаардлага, 30,577.6 мянган төгрөгийн төлбөрийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн байна. Аудитаар өгсөн 246.8 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг биелүүлж, 30,577.6 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	246.8	3	246.8	-	-	-
Зөвлөмж	2	30,577.6	1	30,577.6	1	-	-
Нийт дүн	5	30,824.4	5	30,824.4	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 482,458.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй 3 албан шаардлага, 3 зөвлөмжийг тус тус өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар цалингийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн тушаалын үндэслэл нь дээд газраас ирүүлсэн тушаалтай нийцээгүй, өмнөх аудитын санхүүгийн программ сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст байршуулах 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд Албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал нь 2020 оны А/78 тоот тушаалаар хавсралтад заагдаагүй нэр бүхий 3 ажилтанд 5,676.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" мөн"13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санхүүгийн программуудын шинэчлэлт хийж, сайжруулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 20.2-т "Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж,

захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө”, 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

3. Тайлант онд тус байгууллага нь шилэн дансны цахим хуудаст байршуулах 161 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний дүн, агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 476,781.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн, бүртгэл хяналт, авлага, өглөгийн тооцоо, дотоод аудитын зохион байгуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Өглөг, өр төлбөрийн талаар

Илрүүлэлт: Эм эмнэлгийн хэрэгслийн 2019 оны 366,021.8 мянган төгрөгийн худалдан авалтын үнийг 2020 онд харилцах данснаас шилжүүлсэн, 2020 оны сүүлчээр орлого болгосон, мөнгө нь шилжээгүй эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ болох 359,715.6 мянган төгрөгийг тус тус өр төлбөрийн дансанд бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийсэн актыг батлагдсан маягтаар, хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккумуля сууриар бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл: Санхүүгийн тайлан алдаатай толилуулагдах, байгууллага бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн тооцоо баталгаажаагүй байх.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын дүнг бэлтгэн нийлүүлэгчтэй тухай бүрд тооцоо нийлэн санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, алдааг залруулах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Эм, бараа материалын бүртгэлийн тухай

Илрүүлэлт: Санхүүгийн программ, эмийн программын худалдан авалтын үнийн дүн 115,148.0 мянган төгрөгөөр зөрүүтэй ахлах сувилагч нарын тайланд санхүүгийн баримт дутуу үдэгдсэн, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хяналт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл: Ажил гүйлгээ анхан шатны баримтаар нотлогдохгүй байх.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, дотоод хяналтыг сайжруулах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Цалин хөлс бодолтын тухай

Илрүүлэлт: Ээлжийн амралттай хугацаанд дуудлагаар ажилласан эмч ажилчдад олгосон 1,917.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг захирлын тушаалгүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэл: Дээд газраас гарсан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх.

Өгсөн зөвлөмж: Эрүүл мэндийн сайдын тушаал шийдвэртэй нийцүүлж урамшууллыг олгож байх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021 он	Аудитын нэр: Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/59/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал нь 2020 оны А/78 тоот тушаалаар хавсралтад заагдаагүй нэр бүхий 3 ажилтанд 5,676.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон	5,676.6	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа
2	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санхүүгийн программуудын шинэчлэлт хийж, сайжруулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	-	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа
3	Тайлант онд тус байгууллага нь шилэн дансны цахим хуудаст байршуулах 161 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	-	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа
4	Эм эмнэлгийн хэрэгслийн 2019 оны 366,021.8 мянган төгрөгийн худалдан авалтын үнийг 2020 онд харилцах данснаас шилжүүлсэн, 2020 оны сүүлчээр орлого болгосон, мөнгө нь шилжээгүй эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ болох 359,715.6 мянган төгрөгийг тус тус өр төлбөрийн дансанд бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийсэн актыг батлагдсан маягтаар, хийгээгүй	359,715.6	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа
5	Санхүүгийн программ, эмийн программын худалдан авалтын үнийн дүн 115,148.0 мянган төгрөгөөр зөрүүтэй ахлах сувилагч нарын тайланд санхүүгийн баримт дутуу үдэгдсэн, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хяналт хангалтгүй	115,148.0	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа

6	Ээлжийн амралттай хугацаанд дуудлагаар ажилласан эмч ажилчдад олгосон 1,917.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг захирлын тушаалгүй олгосон	1,917.8	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ш.Энхтөр Д.Байгалмаа
ДҮН		482,458.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 222/А0170064
САГ-2021/59/СТА-ТЧЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал нь 2020 оны А/78 тоот тушаалаар хавсралтад дурдагдаагүй нэр бүхий 3 ажилтанд 5,676.6 /Таван сая зургаан зуун далан зургаан мянга зургаан зуу/ мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, “13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь батлагдсан төсвийн хүрээнд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Ш.Энхтөр, Ахлах нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“БОДЬТУСГАЛ-АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

П.АМАРСАНАА

З.МЯГМАРСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar215.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 222/АД/70064
СДГ-202/59/СТН-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санхүүгийн программуудын шинэчлэлт хийж, сайжруулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.2-т "Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө", 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2-т "журналд бичих" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Захирал Ш.Энхтөр, Ахлах нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"БОДЬТУСГАЛ-АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА

З.МЯГМАРСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264239



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 224/А0170064

Улаанбаатар хот

СМГ-2021/59/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 161 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Захирал Ш.Энхтөр, Ахлах нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"БОДЬТУСГАЛ-АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА

З.МЯГМАРСҮРЭН

З.МЯГМАРСҮРЭН

[illegible]

[illegible]

[illegible]